



МОНГОЛ УЛС
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2024 оны 10 сарын 16 өдөр

Дугаар А/СҮ1

Мөрөн сум

Ажил мэргэжлийн чиг баримжаа олгох
сургалт зохион байгуулах тухай

Монгол Улсын Засаг, захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.5, 66 дугаар зүйлийн 66.1, Боловсролын ерөнхий хуулийн 30 дугаар зүйлийн 30.1.2, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, 41 дүгээр зүйлийн 41.2.2, 41.2.3, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны 09 дүгээр сарын 23-ны өдрийн ээлжит XXVIII хуралдааны 37 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1."Хүүхэд хөгжил, хамгааллыг дэмжих жил"-ийн хүрээнд Мөрөн сумын ерөнхий боловсролын сургуулиудын багш нар болон эцэг эхчүүдэд ажил мэргэжлийн чиг баримжаа олгох сургалт зохион байгуулах хөтөлбөрийг хавсралтаар баталсугай.

2.Хөтөлбөрт зарцуулагдах 10,100,000 (арван сая нэг зуун мянга) төгрөгийг "Хүүхэд хөгжил хамгааллыг дэмжих жил" нэрлэсэн жилийн хүрээнд хэрэгжүүлэх арга хэмжээний зардлаас гаргаж зарцуулахыг аймгийн Засаг даргын Тамгын газар (Э.Улам-Өсөх), нягтлан бодогч (Э.Анхцэцэг) нарт зөвшөөрсүгэй.

3.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Нийгмийн бодлогын хэлтэс (Д.Цэцэгмаа)-т даалгасугай.

ДАРГА



П.ЛХАГВАЖАВ

Аймгийн Засаг даргын 2024 оны 10 дугаар
сарын 16-ны өдрийн 47 дугаар
захирамжийн хавсралт



БАГШ НАР БОЛОН ЭЦЭГ ЭХЧҮҮДЭД АЖИЛ МЭРГЭЖЛИЙН ЧИГ БАРИМЖАА ОЛГОХ ХӨТӨЛБӨР

ТӨСӨЛ ХЭРЭГЖҮҮЛЭХ БОЛСОН ШАЛТГААН:

Монгол Улсын Үндсэн хуулиар иргэн бүр ажил мэргэжлээ чөлөөтэй сонгох... эрхтэй гэж баталгаажуулсан. Мөн төрөөс боловсролын талаарх баримтлах бодлогод “3.5. ...Бүрэн дунд боловсролыг ...ирээдүйд эзэмших мэргэжлийн суурь баримжаа олгох үе хэмээн хөгжүүлнэ” гэж заасан байна.¹ Бүх төрлийн бүх түвшний сургалт хөдөлмөрийн зах зээлтэй холбоотой буюу гинжин нөлөөтэй байдаг. Жишээлбэл Төрөөс хөдөлмөр эрхлэлтийн талаар баримтлах бодлогод “1.1. ...Улс орны хөгжлийн үндэс бол ...иргэн бүр ажил, мэргэжлээ чөлөөтэй сонгох... мөн 4.3.3. оюутан, сурагчдыг хөдөлмөрийн зах зээлд бэлтгэх дадлагын бүх хэлбэрийг дэмжих тогтолцоог бий болгох...” гэжээ.² Боловсролын салбарын үүрэг бол суралцагчдыг хөдөлмөрийн зах зээлд бэлтгэх явдал юм. Гэвч төрөөс олон талт арга хэмжээ авч байгаа боловч хөдөлмөрийн зах зээлийн эрэлт, нийлүүлэлт алдагдаж, ядуурал, ажилгүйдэл буурахгүй байна. Ажил, мэргэжлээ буруу сонгосны хор уршиг нь хувь хүнд болон нийгэмд маш их сөрөг нөлөө үзүүлдэг. Мөн ажил, хөдөлмөр эрхлэхийг хүсэхгүй залуучуудын тоо ч өссөөр байна. Багаас нь ажил, хөдөлмөр эрхлэлтийн үнэ цэнэ, мөн чанар, утга учир, ач холбогдлыг ойлгуулан хүмүүжүүлээгүйн улмаас гарч буй хохирлын хэмжиж баршгүй юм.

Цэдэнжав овогтой Рэгзэнбазар миний бие хувиасаа санхүүжилт гарган 2023-2024 оны хичээлийн жилд Орхон аймгийн Баян-Өндөр сумын ерөнхий боловсролын 5-р сургуулийн 9-р ангийн 5 бүлэг буюу нийт 210 суралцагчдад “Ажил мэргэжлийн чиг баримжаа олгох” сэдвийн хүрээнд суралцагчдын “мэргэжлээ сонгох чадамж”-ийг дээшлүүлэх 5 сарын сургалт явууллаа. Энэхүү сургалтын явцад 3 удаа 93 асуумжтай судалгаа авч харьцуулан судалсан. Энэхүү туршилт сургалтаар “суралцагчийн ажил мэргэжлийн төлөвлөгч дэвтэр” гарын авлага болон “миний ажил мэргэжлийн төлөвлөгөө” үзүүлэнг туршсан. Туршилт судалгааг МУБИС-ын эрдэмтэн багш нартай хамтран явуулсан бөгөөд “Боловсролын судалгааны арга зүй, хэрэглээ VI”-2024 сэдэвт эрдэм шинжилгээний хуралд оролцож илтгэл тавьсан билээ.

Хөвсгөл аймгийн Мөрөн сумын Ерөнхий боловсролын 8, 9-р анги удирдсан 30 багш, нийт 80 гаруй эцэг, эх болон асран хамгаалагчид ажил мэргэжлийн чиг баримжаа олгох сургалт явуулна. Төслийн нийт хөрөнгө оруулалт 10.1 сая төгрөг болно. Нийт хөрөнгө оруулалтын 79% нь багш нарт сургалт явуулах зардал болон сурах бичгийн зардал орно. Харин 21% нь эцэг эх болон асран хамгаалагчдад сургалт явуулах зардал юм.

ТӨСЛИЙН ЭРХЭМ ЗОРИЛГО:

- ЕБС-ийн суралцагчдад “АЖИЛ МЭРГЭЖЛИЙН ЧИГ БАРИМЖАА” олгох.

¹ Төрөөс боловсролын талаар баримтлах бодлого. УИХ-ын 2015 оны 12 дугаар тогтоолын хавсралт

² Төрөөс хөдөлмөр эрхлэлтийн талаар баримтлах бодлого. Засгийн газрын 2016 оны 320 тогтоолын хавсралт

ТӨСЛИЙН ЗОРИЛГО:

- Хөвсгөл аймгийн Мөрөн сумын ЕБС-ийн VIII-IX ангийн **30** багш нар болон эцэг эх асран хамгаалагчдад ажил, мэргэжлийн чиг баримжаа олгох **сургалт явуулна.**

ТӨСӨЛ ХЭРЭГЖҮҮЛЭГЧ БАГШИЙН ТУРШЛАГА:

- 2023-2024 оны хичээлийн жилд Орхон аймгийн Баян-Өндөр сумын ерөнхий боловсролын 5-р сургуулийн 9-р ангийн 5 бүлэг буюу нийт 210 суралцагчдад “Ажил мэргэжлийн чиг баримжаа олгох” сэдвийн хүрээнд суралцагчдын “мэргэжлээ сонгох чадамж”-ийг дээшлүүлэх 5 сарын туршилт сургалт явуулж “Боловсролын судалгааны арга зүй, хэрэглээ VI”-2024 сэдэвт эрдэм шинжилгээний хуралд оролцож илтгэл тавьсан.
- Ц.Рэгзэнбазар нь “Давуу талаа шинжин таних арга”, “Сурагчийн ажил мэргэжлээ төлөвлөгч дэвтэр”, “Мэргэжлээ сонгохуйн нууц ба мөнгөний үнэ цэнэ” номын зохиогч юм.
- МУБИС-ын 2021 оны докторант. “Суралцагчдын мэргэжлээ сонгох чадамжийг дээшлүүлэх нэмэлт хөтөлбөрийн туршилтын үр дүн” сэдвээр докторын диссертаци бичиж байгаа.

ТӨСЛӨӨС ҮР ШИМ ХҮРТЭГСЭД:

А. Эцэг, эхчүүд:

- Хөвсгөл аймгийн Мөрөн сумын ЕБС-ийн VIII-IX дүгээр ангийн нийт **80** Эцэг, эх, асран хамгаалагчид.

В. Багш нар:

- Хөвсгөл аймгийн Мөрөн сумын ЕБС-ийн VIII-IX дүгээр ангийн нийт **30** багш нар.

Г. Ерөнхий боловсролын сургуулиуд:

- Хөвсгөл аймгийн Мөрөн сумын Ерөнхий боловсролын **5** сургууль үр шимийг хүртэнэ.

ЧАДАМЖИД СУУРИЛСАН СУРГАЛТЫН АРГА ЗҮЙ:

Чадамжид суурилсан сургалтын арга зүй нь суралцагч бүрийн чадамж өөр хоорондоо харилцан адилгүй гэдгийг хүлээн зөвшөөрдөг. Энэхүү сургалтын үйл явцад суралцагч бүр өөр өөрийн хэм хэмжээнд тохируулан суралцах боломжтой. Чадамжид суурилсан сургалтаар суралцагч цагийг уян хатан ашигласны үр дүнд өөрийн сурах хурдад тохируулан мэдлэг, ур чадвараа ахиулах боломжийг олгодог. (Donohue, 2013). Чадамжид суурилсан сургалтын тогтолцоонд суралцагч урьдчилан төлөвлөсөн чадамжид хүрэхийн тулд мэдлэг, ур чадвараа ахиулдаг. Чадамжид суурилсан сургалт нь суралцагчдад төвлөрч тэдэнд чиглэгдсэн байдаг. Түүний тулгуур үзэл баримтлал бол туршихуйн сургалт юм.

“Туршихуйн сургалт” нь (Experiential Learning) хийх замаар суралцах үйл явц юм. Суралцагчдыг практик туршлага, эргэцүүлэн тунгаан бодоход татан оролцуулснаар сурсан онол болон практик мэдлэгээ бодит үйл ажиллагаанд хэрэглэж чаддаг болно. Туршихуйн сургалт нь хийх замаар суралцах үйл явц юм. Суралцагчдыг практик туршлага, эргэцүүлэн тунгаан бодоход татан оролцуулснаар сурсан онол болон практик мэдлэгээ бодит үйл ажиллагаанд хэрэглэж чаддаг болно.

**ХӨВСГӨЛ АЙМГИЙН МӨРӨН СУМЫН ЕБС-ИЙН VIII-IX АНГИЙН БАГШ НАР БОЛОН
ЭЦЭГ ЭХ, АСРАН ХАМГААЛАГЧДАД АЖИЛ, МЭРГЭЖЛИЙН ЧИГ БАРИМЖАА ОЛГОХ 2
ӨДРИЙН СУРГАЛТ ЯВУУЛАХ ТӨЛӨВЛӨГӨӨ**

I үе шат: ЕБС-ИЙН VIII-IX АНГИЙН БАГШ НАРТ АЖИЛ МЭРГЭЖЛИЙН ЧИГ БАРИМЖАА ОЛГОХ СУРГАЛТ

Үйл ажиллагаа-01:

Зорилго:

- Хөвсгөл аймгийн Мөрөн сумын ЕБС-ийн VIII-IX ангийн багш нарт ажил мэргэжлийн чиг баримжаа олгох 2 өдрийн 8 цагийн сургалт

Хүснэгт -01: Хөрөнгө оруулалтын зардлын задаргаа:

№	Хэрэгжүүлэх арга хэмжээ	х/н	Нэг бүрийн үнэ /төг/	тайлбар	Бүгд /мян,төг/
1.	VIII-IX ангийн Багшийн гарын авлага	30 ш	25.000	Багшийн гарын авлагын дагуу сургалт явуулах эхний өдөр	750.000
2.	VIII-IX ангийн “Суралцагчдын ажил мэргэжлээ төлөвлөгч дэвтэр”	30 ш	30.000	Сурагчдын гарын авлагын дагуу сургалт явуулах хоёр дахь өдөр	900.000
3.	VIII-IX ангийн суралцагчийн ажил мэргэжлийн төлөвлөгөө	30ш	5.000	Ажил мэргэжлийн төлөвлөгөөг ашиглах аргачлал заах	150.000
4.	“Давуу талаа шинжин таних арга” - 2023 он Ц.Рэгзэнбазар	30ш	50.000	Ном сурах бичиг ашиглах	1.500.000
5.	“Мэргэжлээ сонгохуй ба мөнгөний үнэ цэнэ”-2021 он Ц.Рэгзэнбазар	30ш	50.000	Ном сурах бичиг ашиглах	1.500.000
6.	Сургалт явуулах төлбөр	8 цаг	400.000	Нийт 30 багш нарт 2 өдөр ажил мэргэжлийн чиг баримжаа олгох ур чадвар олгоно.	3.200.000
7.					8.000.000

II үе шат: ЕБС-ИЙН VIII-XI АНГИЙН ЭЦЭГ ЭХ, АСРАН ХАМГААЛАГЧДАД АЖИЛ МЭРГЭЖЛИЙН ЧИГ БАРИМЖАА ОЛГОХ СУРГАЛТ:

Үйл ажиллагаа-01:

Зорилго:

- ЕБС-ийн VIII-XI ангийн эцэг эх асран хамгаалагчдад ажил мэргэжлийн чиг баримжаа олгох сургалт явуулах

Хүснэгт -02: Хөрөнгө оруулалтын зардлын задаргаа:

№	Хэрэгжүүлэх арга хэмжээ	х/н	Нэг бүрийн үнэ /төг/	тайлбар	Бүгд /мян,төг/
1.	ЕБС-ийн VIII-XI ангийн эцэг эх асран хамгаалагчдад	6 цаг	350.000	Нийт 80 эцэг эхчүүд асран хамгаалагчдад 2 удаа сургалт явуулах	2.100.000

	Нийт				2.100.000
--	-------------	--	--	--	------------------

Хүснэгт -03: Нийт хөрөнгө оруулалтын зардлын задаргаа:

№	Хэрэгжүүлэх арга хэмжээ	х/н	Нэг бүрийн үнэ /төг/	тайлбар	Бүгд /мян,төг/
1.	ЕБС-ийн VIII-IX ангийн багш нар				8.000.000
2.	ЕБС-ийн VIII-XI ангийн эцэг эх асран хамгаалагчдад	6 цаг	350.000	Нийт 80 эцэг эхчүүд асран хамгаалагчдад 2 удаа сургалт явуулах	2.100.000
	Нийт				10.100.000

Төсөл боловсруулсан:

Боловсрол судлалын докторант Ц.Рэгзэнбазар

ДАРГА

ПЛАТБАЖАВ